



What do I need to know if my child gets a formal caution?

Parent/carer information

Миний хүүхэд сургуулиас албан сануулга авсан бол би юу мэдэж байх ёстой вэ?

Эцэг эх/асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Зохисгүй зан авирын албан сануулга гэж юу вэ?

Зохисгүй зан авир гэдэг нь хэн нэгэн өөртөө болон бусдад аюул, хохирол учруулж болзошгүй эсвэл учруулсан ямар нэгэн үйлдэл гаргахыг хэлнэ. Албан сануулга бол тухайн сурагчид түүний зан авир өөрт нь болон бусдад аюул, хохирол учруулж болзошгүй эсвэл учруулсан тухайг нь мэдэгдэж байгаа хэрэг юм. Энэ нь та болон таны хүүхдэд уг зан авирыг засах шаардлага байгааг анхааруулах зорилготой юм.

Албан сануулга нь таны хүүхдийн асуудал бүхий зан авир гаргасныг дурдсан захиа юм. Таны хүүхэд энэ үед сургуулиас чөлөөлөгдөхгүй.

Хэрвээ миний хүүхэд албан сануулга авбал юу болох вэ?

Сургууль гаргасан асуудал бүхий зан авирын талаарх албан сануулгын талаар тантай ярилцаж таны хүүхдэд үүнийг тайлбарлах болно. Мөн сургуулийн захирал албан сануулгын нэг хувийг танд өгөх болно.

Албан сануулгын зорилго нь та болон таны хүүхдэд уг зүй бус зан авирын үр дагаврыг ойлгох, хүүхдэд дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөг хүлээн зөвшөөрөх цаг хугацаа олгох зорилготой. Сургуулийн зүгээс та болон таны хүүхдэд тухайн зан авирын талаар ярилцаж, таны хүүхдэд хэрэгтэй байгаа дэмжлэг, тусламжийг нягталж, төлөвлөх зорилгоор уулзах боломж олгох болно.

Та суургуультай уулзах аливаа уулзалтанд өөрт тань [дэмжлэг үзүүлэх хэн нэгэнтэй](#) хамт ирж болно.

Зохисгүй зан авирын албан сануулга нь хичээлийн 50 хүртэлх өдрийн хугацаанд хүчинтэй. Хэрвээ энэ хугацаанд хүүхдийн тухайн зан авир дахин давтах буюу өөр мөн ижил зан авир гаргавал таны хүүхэд сургуулиас түр чөлөөлөгдөх магадлалтай.

Хэрвээ миний хүүхэд албан сануулга авбал би юу хийх вэ?

Сургуулийн дүрэм эсвэл [Сурагчдын Зан Авирын Дүрмийг](#) зөрчсөн үйлдлийг бараг хүүхэд бүр л гаргадаг. Ийм тохиолдолд заримдаа эдгээр зөрчлүүд дээр албан сануулга өгөх тохиолдол байдаг. Нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийг [хэрвээ таны хүүхэд сургууль дээрээ асуудалд орвол юу хийх тухай](#) хэсгээс авна уу.

Хэрэв таны хүүхэд албан сануулга авсан бол түүнд анхаарал хандуулах шаардлагатай зан авир байна гэсэн үг юм. Хүүхдийнхээ бие авч явах байдал зан авирыг сайжруулах, тохирох шийдэл арга замыг хамтдаа тодорхойлоход таны сургуультай хамтран ажиллах явц маш чухал үүрэгтэй юм. Албан сануулгын талаар сургуулийн захиралтай ярилцан, сургуулийн багтай хамтран ажиллаж, таны хүүхдэд дэмжлэг үзүүлэх шийдлүүдийг хамтдаа гаргаарай.

Хэрвээ тухайн зан авир дахин давтагдвал яах вэ?

Хэрвээ тухайн зохисгүй зан авир нь албан сануулга авснаас хойшхи хичээлийн 50 өдрийн дотор дахин давтагдвал сургуулийн захирал таны хүүхдийг сургуулиас түр чөлөөлөх шийдвэр гаргах боломжтой. Сургуулиас түр чөлөөлөх шийдвэрийг зөвхөн сургуулийн захирал тухайн гаргасан зан авир, таны хүүхдийн болон бусад хүүхдүүдийн хэрэгцээг харгалзан үзсэний үндсэн дээр гаргана. [Сурагчийг сургуулиас түр чөлөөлөх тухай мэдээлэл](#)-тэй та танилцах боломжтой.

Хэрвээ надад санаа зовнисон асуудал хэвээр байвал би яах вэ?

Хэрвээ та сургууль дээр хүүхдийнхээ сурлага, зан авир эсвэл сайн сайхан байдалд санаа зовнисон асуудал байвал хамгийн түрүүнд ангийн багш, туслах эсвэл орлогч захиралтай ярилцах нь зүйтэй. Ихэнх асуудлуудыг таны хүүхэд болон тухайн нөхцөл байдлыг сайн мэдэх хүмүүстэй ярилцсанаар шийдэх боломжтой байдаг.

Зарим тохиолдолд та өөр хэн нэгэнтэй ярилцах шаардлагатай байж болох юм. Танд туслах харьяа боловсролын хэлтсийнхээ холбоо барих мэдээллийг сургуулиасаа авах боломжтой. Мөн хэрвээ таны санаа зовнисон асуудал эрүүл мэндийн шалтгаантай байж болзошгүй гэж үзвэл хүүхдийнхээ эмчид хандах талаар бодож үзээрэй.

[Хүүхдээ өмгөөлөх](#) тухай мэдээлэл авах боломж танд нээлттэй ба мөн [Сургуулийн Хүрээлэлд Баримтлах Дүрэм](#)-д сургуультай энэ талаар харилцах арга замуудын тухай дурдсан байгаа.

Сургуулийн зүгээс надад ямар мэдээллийг өгч чадах вэ?

Юу болсон, яагаад болсон талаар нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийг та сургуулиас асууж болно. Сургууль танд өөрийн гаргасан аливаа шийдвэрийн цаад учир шалтгаан, мөн ямар арга хэмжээ авах, танд ямар нэгэн асуудал гарвал яах ёстойг тайлбарлах ёстой байдаг.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.